ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Татварын хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ОРА-2021/81/СТА-ТШЗ


Цахим хуудас: www.audit.mn
Орхон аймаг
2021 он

| | |
|---|---|
| Тэргүүлэх аудитор: | Ц.Нармандах |
| Утас: 70353088 | Цахим хаяг: orkhon@audit.gov.mn |
| Аудитын менежер: | Б.Эрдэнэ |
| Утас:70355805 | Цахим хаяг: orkhon@audit.gov.mn |
| Гэрээт ажилтан: | Ш.Уганжаргал |
| Утас:70355805 | Цахим хаяг: orkhon@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ... 6,7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ... 8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ... 10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 10,11
3. Аудитын тайлан ... 13
3.1. Ерөнхий зүйл ... 13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ... 13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ... 13
3.4. Материаллаг байдал ... 14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ... 14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ... 15
3.7. Шилэн дансны мэдээлэл ... 16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ... 16
3.9. Аудитын илрүүлэлт ... 16
Залруулсан алдаа ... 17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ... 17
Аудитын зөвлөмж ... 17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ... 17
4. Менежментийн захидал ... 18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ... 19

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.23 № 13

танай ______________-ны № ______________-т

ОРХОН АЙМГИЙН ТАТВАРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА
Б.ЦЭВЭЭНСҮРЭН ТАНАА

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Татварын хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Татварын хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

D:\my doc \albanbichig\ 2021-
A4.doc

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**СТ-1А**

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **47,485,891.08** | **44,698,852.91** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **12,888,955.00** | **5,568,955.00** |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | 0.00 | 0.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **12,888,955.00** | **5,568,955.00** |
| **3121** | **Төгрөг** | **12,888,955.00** | **5,568,955.00** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 12,888,955.00 | 5,568,955.00 |
| **33** | **АВЛАГА** | **1,097,917.90** | **0.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 0.00 | 0.00 |
| **335** | **Бусад авлага** | 1,097,917.90 | 0.00 |
| **3351** | **Байгууллагаас авах авлага** | 1,097,917.90 | 0.00 |
| **3352** | **Хувь хүмүүсээс авах авлага** | 0.00 | 0.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **33,499,018.18** | **39,129,897.91** |
| **351** | **Түүхий эд материал** | **0.00** | **0.00** |
| **354** | **Хангамжийн материал** | **33,499,018.18** | **39,129,897.91** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,312,420.00 | 10,287,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 20,889,845.00 | 25,442,505.91 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 4,749,800.00 | 1,391,200.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,840,000.00 | 1,566,392.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,706,953.18 | 442,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **499,765,643.27** | **805,537,086.83** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **499,765,643.27** | **805,537,086.83** |
| **392** | **Биет хөрөнгө** | **423,925,643.27** | **729,697,086.83** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 330,669,660.00 | 330,669,660.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -12,989,141.85 | -26,013,870.39 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 45,000,000.00 | 161,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -5,629,618.48 | -17,941,965.84 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 127,792,946.00 | 251,646,980.49 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -100,931,828.11 | -44,742,604.68 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 110,407,450.00 | 138,253,817.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -70,393,824.29 | -63,974,929.75 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **75,840,000.00** | **75,840,000.00** |
| 39301 | Програм хангамж | 1,430,000.00 | 1,430,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,430,000.00 | -1,430,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 75,840,000.00 | 75,840,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **547,251,534.35** | **850,235,939.74** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **0.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **0.00** |
| **413** | **Өглөг** | **0.00** | **0.00** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **547,251,534.35** | **850,235,939.74** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **547,251,534.35** | **850,235,939.74** |

| | | | |
|---|---|---|---|
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | 720,858,474.98 | 720,858,474.98 |
| 51101 | Өмч: - төрийн | 720,858,474.98 | 720,858,474.98 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 0.00 | 0.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **-188,995,810.63** | **113,988,594.76** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -152,167,450.62 | -190,093,728.53 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -36,828,360.01 | 304,082,323.29 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 15,388,870.00 | 15,388,870.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **547,251,534.35** | **850,235,939.74** |

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,073,728,240.00** | **1,432,375,898.03** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **0.00** | **0.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **61,801,840.00** | **366,689,234.03** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **61,801,840.00** | **366,689,234.03** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 61,641,840.00 | 366,689,234.03 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,399,750.00 | 0.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 58,242,090.00 | 366,689,234.03 |
| 120005 | Түрээсийн орлого | 160,000.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,011,926,400.00** | **1,065,686,664.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **837,224,300.00** | **928,013,464.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 837,224,300.00 | 928,013,464.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **174,702,100.00** | **137,673,200.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 173,702,100.00 | 137,673,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,000,000.00 | 0.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **0.00** | **0.00** |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,066,194,454.48** | **1,126,767,793.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,066,194,454.48** | **1,126,767,793.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,012,123,804.52** | **1,030,226,538.81** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **641,258,562.17** | **714,165,485.88** |
| 210101 | Үндсэн цалин | 513,080,869.75 | 491,797,892.69 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 114,199,192.42 | 122,944,694.43 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,978,500.00 | 46,760,000.00 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 52,662,898.76 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **89,261,100.00** | **93,823,686.30** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 65,063,500.00 | 65,430,386.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,049,400.00 | 7,098,300.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгал | 4,839,500.00 | 5,678,700.00 |
| 210204 | Ажилгүйдлын даатгал | 1,209,900.00 | 1,419,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,098,800.00 | 14,196,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **16,828,694.83** | **20,191,158.81** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 5,927,226.67 | 5,588,002.74 |
| 210302 | Түлш, халаалт | 7,217,863.16 | 9,228,645.01 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,683,605.00 | 5,374,511.06 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **27,060,723.04** | **52,884,595.11** |
| 210401 | Бичиг хэрэг | 10,190,540.00 | 18,018,722.00 |
| 210402 | Тээвэр шатахуун | 7,199,322.00 | 8,482,021.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 7,724,811.04 | 8,645,955.11 |
| 210404 | Ном, хэвлэл | 290,500.00 | 27,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 338,000.00 | 630,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,317,550.00 | 6,468,395.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0.00 | 10,611,602.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **0.00** | **740,000.00** |
| 210503 | Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 740,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **65,893,788.00** | **13,279,550.00** |
| 210604 | Урсгал засвар | 65,893,788.00 | 13,279,550.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,997,900.00** | **2,542,600.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,997,900.00 | 2,542,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **54,577,519.82** | **48,223,353.16** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 50,581,100.00 | 44,735,699.98 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 620,000.00 | 864,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 344,536.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 90,200.00 | 90,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 87,000.00 | 22,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 568,800.00 | 656,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,285,883.82 | 1,855,453.18 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **111,245,516.66** | **84,376,109.55** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,282,500.00 | 5,455,759.63 |
| 210902 | Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх | 68,992,170.00 | 29,418,818.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал | 39,970,846.66 | 49,501,531.92 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **54,070,649.96** | **96,541,254.92** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **0.00** | **1,058,400.00** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0.00 | 1,058,400.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **48,623,940.00** | **80,375,481.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,719,000.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 41,489,700.00 | 65,923,481.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,415,240.00 | 14,452,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **5,446,709.96** | **15,107,373.92** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,446,709.96 | 15,107,373.92 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **7,533,785.52** | **305,608,104.30** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **0.00** | **0.00** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **44,362,145.53** | **1,525,781.01** |
| 225001 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз | 44,362,145.53 | 1,198,169.01 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 0.00 | 327,612.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -44,362,145.53 | -1,525,781.01 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | -36,828,360.01 | 304,082,323.29 |

**СТ-3А**

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 1,015,846,150.00 | 1,065,686,664.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 1,011,926,400.00 | 1,065,686,664.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 837,224,300.00 | 928,013,464.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 837,224,300.00 | 928,013,464.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,000,000.00 | 137,673,200.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 137,673,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,000,000.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 173,702,100.00 | 0.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 173,702,100.00 | 0.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 988,485,215.00 | 1,066,397,664.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 988,485,215.00 | 1,066,397,664.00 |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 934,414,565.04 | 969,856,409.08 |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | 641,258,562.17 | 714,165,485.88 |
| 210101 | Үндсэн цалин | 407,871,462.24 | 491,797,892.69 |
| 210102 | Нэмэгдэл | 146,929,799.96 | 122,944,694.43 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 32,563,799.97 | 46,760,000.00 |
| 210104 | Урамшуулал | 53,893,500.00 | 52,662,898.76 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 89,261,100.00 | 93,823,686.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 65,063,500.00 | 65,430,386.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,049,400.00 | 7,098,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,839,500.00 | 5,678,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,209,900.00 | 1,419,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,098,800.00 | 14,196,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,828,694.83 | 20,191,158.81 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,927,226.67 | 5,588,002.74 |
| 210302 | Түлш, халаалт | 7,217,863.16 | 9,228,645.01 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,683,605.00 | 5,374,511.06 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27,762,601.04 | 36,554,755.11 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,796,740.00 | 7,372,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,000,000.00 | 8,296,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,724,811.04 | 9,714,955.11 |
| 210404 | Ном, хэвлэл | 290,500.00 | 417,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 338,000.00 | 630,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,612,550.00 | 10,123,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 440,000.00 | 300,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 440,000.00 | 300,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 28,225,766.00 | 11,745,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 60,000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 28,165,766.00 | 11,745,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,997,900.00 | 2,542,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,997,900.00 | 2,542,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 52,291,636.00 | 50,729,899.98 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 50,581,100.00 | 49,097,699.98 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 620,000.00 | 864,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 344,536.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 90,200.00 | 90,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 87,000.00 | 22,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 568,800.00 | 656,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 72,348,305.00 | 39,803,623.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 2,351,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 72,348,305.00 | 37,452,623.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 54,070,649.96 | 96,541,254.92 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 0.00 | 1,058,400.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0.00 | 1,058,400.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 48,623,940.00 | 80,375,481.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,719,000.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 41,489,700.00 | 65,923,481.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,415,240.00 | 14,452,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 5,446,709.96 | 15,107,373.92 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,446,709.96 | 15,107,373.92 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | 27,000,935.00 | -711,000.00 |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | 0.00 | 0.00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | 14,111,980.00 | 6,609,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 14,111,980.00 | 6,609,000.00 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 14,111,980.00 | 6,609,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 14,111,980.00 | 6,609,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | -14,111,980.00 | -6,609,000.00 |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН** | | |

| | | | |
|---|---|---|---|
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 0.00 | 0.00 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 12,888,955.00 | -7,320,000.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 12,888,955.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 12,888,955.00 | 5,568,955.00 |

**СТ-4А**

## ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | 2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 720,858,474.98 | 15,388,870.00 | -152,167,450.62 | 0.00 | 584,079,894.36 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 720,858,474.98 | 15,388,870.00 | -152,167,450.62 | 0.00 | 584,079,894.36 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -36,828,360.01 | 0.00 | -36,828,360.01 |
| C08 | 2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 720,858,474.98 | 15,388,870.00 | -188,995,810.63 | 0.00 | 547,251,534.35 |
| D01 | 2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 720,858,474.98 | 15,388,870.00 | -188,995,810.63 | 0.00 | 547,251,534.35 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 720,858,474.98 | 15,388,870.00 | -188,995,810.63 | 0.00 | 547,251,534.35 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | -1,097,917.90 | 0.00 | -1,097,917.90 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 304,082,323.29 | 0.00 | 304,082,323.29 |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 720,858,474.98 | 15,388,870.00 | 113,988,594.76 | 0.00 | 850,235,939.74 |

ТГ

## Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **928,013,600.00** | **935,333,464.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **928,013,600.00** | **935,333,464.00** |
| 210 | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **852,894,500.00** | **841,909,118.95** |
| 2101 | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **652,738,400.00** | **641,429,365.31** |
| 210101 | Үндсэн цалин | 425,607,400.00 | 419,061,771.12 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 135,611,700.00 | 122,944,694.43 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 20,196,000.00 | 46,760,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 71,323,300.00 | 52,662,898.76 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **84,592,300.00** | **84,212,216.03** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 56,199,000.00 | 55,818,916.03 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,098,300.00 | 7,098,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,678,700.00 | 5,678,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,419,700.00 | 1,419,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,196,600.00 | 14,196,600.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **21,005,100.00** | **20,191,158.81** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,540,000.00 | 5,588,002.74 |
| 210302 | Түлш, халаалт | 9,781,500.00 | 9,228,645.01 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,683,600.00 | 5,374,511.06 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **23,530,900.00** | **23,426,030.82** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,579,900.00 | 3,572,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,296,000.00 | 4,296,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,212,800.00 | 8,186,030.82 |
| 210404 | Ном, хэвлэл | 447,600.00 | 417,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 670,600.00 | 630,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,324,000.00 | 6,324,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,747,600.00** | **6,747,600.00** |
| 210604 | Урсгал засвар | 6,747,600.00 | 6,747,600.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **2,920,000.00** | **2,542,600.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,920,000.00 | 2,542,600.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **36,998,200.00** | **38,998,199.98** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 35,366,000.00 | 37,365,999.98 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 864,000.00 | 864,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 90,200.00 | 90,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 656,000.00 | 656,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **24,362,000.00** | **24,361,948.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,960,000.00 | 8,960,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага | 15,402,000.00 | 15,401,948.00 |
| 212 | **ТАТААС** | **0.00** | **12,990,464.05** |
| 2121 | **Төрийн өмчит байгууллагад олгох татаас** | **0.00** | **12,990,464.05** |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 0.00 | 12,990,464.05 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **75,119,100.00** | **80,433,881.00** |
| 2131 | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **1,058,400.00** | **1,058,400.00** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 1,058,400.00 | 1,058,400.00 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **74,060,700.00** | **79,375,481.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 65,923,700.00 | 65,923,481.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,137,000.00 | 13,452,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **928,013,600.00** | **928,013,464.00** |
| 1310 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **928,013,600.00** | **928,013,464.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 928,013,600.00 | 928,013,464.00 |
| 88 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0.00** | **5,568,955.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 88 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0.00** | **0.00** |
| 6 | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **0.00** | **0.00** |
| 61 | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 62 | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **47.00** | **47.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 33.00 | 33.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 13.00 | 13.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 0.00 | 0.00 |
| 65 | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **0.00** | **0.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 34.00 | 34.00 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 0.00 | 0.00 |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | 0.00 | 0.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 13.00 | 13.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 0.00 | 0.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Татварын хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Б.Цэвээнсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны бүртгэл хөтлөлтийг сайжруулж нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Эрдэнэ, гэрээт ажилтан Ш.Ууганжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Татварын хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ны өдрийн 01/70 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон аймгийн татварын хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Хуулиар хүлээсэн үндсэн үүргээ биелүүлэхээс гадна тайланд оныг “Цахим татварын жил” болгон зарласан байна.

Эрхэм зорилго:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах,
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих,
- Төсвийн орлого бүрдүүлэх
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Орхон аймгийн татварын хэлтсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 205701.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2057.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлого 1425005.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 14250.0 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн татварын хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 302984.4 мянган төгрөгөөр буюу 55.4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 47,485.9 | 44,698.9 | -2,787,.1 |
| МӨНГӨН ХӨРӨНГӨ | 12,888.9 | 5,568.9 | -7,320.0 |
| АВЛАГА | 1,097.9 | 0.00 | -1,097.9 |
| БАРАА МАТЕРИАЛ | 33,499.0 | 39,129.9 | 5,630.9 |
| НӨӨЦИЙН БАРАА | 0.00 | 0.00 | 0.00 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 499,765.6 | 805,537.1 | 305,771.4 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 499,765.6 | 805,537.1 | 305,771.4 |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР | 0.00 | 0.00 | 0.00 |
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 0.00 | 0.00 | 0.00 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 547,251.5 | 850,235.9 | 302,984.4 |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 5568.9 мянган төгрөг болж 7320.0 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн дансны мөнгөнөөс зарцуулсан нь шалтгаалжээ.

Авлагын дансны үлдэгдэл 1097.9 мянган төгрөгөөр буурсан нь 1997 онд үүссэн Сэргээн босголт банктай холбоотой авлагыг барагдуулахаар холбогдох байгууллагуудад хүсэлт гарган шүүхийн шийдвэрийн дагуу хасалт хийсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 5630.9 мянган төгрөгөөр өссөн нь МУЗГ, сангийн яамнаас Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлж буй 3709-МОН төслийн хүрээнд болон татварын ерөнхий газраас ирүүлсэн бичиг хэрэг, аж ахуйн материалыг хүлээн авсан,

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл мөн өмнөх оны үлдэгдлээс 305771.4 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний зардлаас 54527.0, татварын

ерөнхий газраас 116800.0 мянган төгрөгийн автомашин балансаас балансад шилжиж ирсэн мөн МУЗГ, сангийн яамнаас Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлж буй 3709-МОН төслийн хүрээнд тоног төхөөрөмжүүдийг хүлээн авснаар тус тус өссөн байна.

Орхон аймгийн татварын хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 358647.6 мянган төгрөгөөр буюу 33.4 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 60573.3 мянган төгрөгөөр буюу 5.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс ба нэмэгдэл цалингийн зардлууд байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 472 дугаар тогтоолоор үндсэн цалингийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой мөн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардал 24433.8 мянган төгрөг буюу 58.9 хувь, хог хаягдал хортон устгалын зардал цар тахалтай холбоотойгоор 292.0 мянган төгрөг буюу 86.4 хувиар тус тус зардлууд өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 1097.9 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь 1997 онд үүссэн Сэргээн босголт банктай холбоотой авлагыг барагдуулахаар холбогдох байгууллагуудад хүсэлт гарган Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 9-р сарын 14-ний өдрийн шийдвэрээр дээрх авлагыг хүчингүй болгосноор данснаас хасалт хийсэнтэй холбоотой байна.

### 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 958901.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 958901.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 30887.6 мянган төгрөгөөр хорогдуулж 928013,6 мянган төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн 17 арга хэмжээг санхүүжүүлэхээр 928013.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 137673.2 мянган төгрөг нийт 1065686.8 мянган төгрөгийн төсөв батлан санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Нийт 1065686.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1050579.4 мянган төгрөгийг зарцуулж 15107.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 915021.4 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь байр ашиглалтын зардлыг 813.9 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардлыг 104.9 мянган төгрөг, томилолтын зардлыг 377.4, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 5000.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвөөс 110173.2 аймгийн Засаг даргын захирамжаар татвар төлөгчдийн өдөр, татварын багц хуулийг сурталчлах, бэлэн байдлыг хангах, төрийн үйлчилгээг цахимжуулах зэрэгт 27500.0 мянган нийт 137673.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс гэрээт ажилчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 82347.6, хангамжийн бараа материалын зардалд 13128.7, нормын хувцас зөөлөн эдлэлд 300.0, урсгал засварт 4997.6, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 11731.7, хичээл үйлдвэрлэлийн дадлагад 22050.7, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 1000.0 нийт 135556.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2116.9 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

### 3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй, хугацаандаа оруулбал зохих бүх мэдээллийг байршуулсан байна. Хөрөнгийн зарцуулалттай холбоотой удирдлагын шийдвэрийг тухай бүр мэдээлсэн байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 430.0 мянган төгрөгийн 1 акт, 54600.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 6 зөвлөмж өгсөн бөгөөд биелэлт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт. /сая.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 0.43 | 1 | 0.43 | | | 100 |
| Албан шаардлага | 1 | 54.6 | 1 | 54.6 | | | |
| Зөвлөмж | 6 | | 6 | | | | 100 |
| Нийт дүн | 3 | 55.03 | 3 | 55.03 | | | 100 |

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9916.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 872.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Өмчийн өөрчлөлтийн тайланд найдваргүй авлагын хасагдуулгын 1097.9 мянган төгрөгөөр хуримтлагдсан үр дүнг бууруулах бичилт хийгээгүйг залруулсан.

2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогод үнэ төлбөргүй хүлэн авсан хөрөнгийн орлогыг 7370.5 мянган төгрөгөөр дутуу тусгасныг залруулсан.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 1448.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 872.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Татварын Ерөнхий газрын даргын 2020 оны 05-р сарын 28-ны А/103 тоот тушаалаар батлагдсан "харьяа нэгжийн орон тоог шинэчлэн батлах тухай" тушаалын хоёрдугаар хавсралтад тус хэлтэст цахилгаанчин-мужааны орон тоо батлагдаагүй байхад Төсвийн тухай хуулийн 16.5.3."батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалтыг зөрчин тус байгууллагын даргын 2020 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн А/61 тоот тушаалаар жолооч Б.Өлзийбаярт байгууллагын цахилгаанчин-мужааны ажлыг хавсран гүйцэтгүүлж сар бүр үндсэн цалингийн 30 хувийн нэмэгдэл олгохоор шийдвэрлэн 11,12 саруудад 311.7 мянган төгрөг олгосон нь үнэн зөв байдал, үнэлгээ гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.*

2. Тус байгууллагын даргын 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн Б/21 тоот тушаалаар Ц.Отгонцэрэнг 8-р сарын 20-ноос, 11-р сарын 09-ний Б/29 тоот тушаалаар Д.Гэндэнпилийг мөн өдрөөс ажилд авсан боловч цалин нэмэгдлийг олгохдоо томилогдсон тухайн саруудад бүтэн ажилласнаар тооцож 560.3 мянган төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", нийцэхгүй, үнэн зөв байдал, үнэлгээ гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.*

**Аудитын зөвлөмж**

**1. *Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал***

1.1 *Илрүүлэлт:* Жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хянаагүй, 11,12 сарын 3479УБЕ автомашины жолоочийн тооцооны хуудсыг няравын тайланд архивлаж үдээгүй байна.

1.2 *Эрсдэл:* Холбогдох хууль тогтоомж, заавар журмын хэрэгжилт хангагдахгүй байх.

1.3 *Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.5."Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалтуудыг бүрэн хэрэгжүүлж, дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Орхон аймгийн татварын хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд анхаарал татахуйц асуудал байхгүй байна гэж үзлээ.

Орхон аймгийн Татварын хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал*

1.1. ***Илрүүлэлт:***

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.5."Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтууд бүрэн хэрэгжихгүй дотоод хяналт сул байна.

1.2. ***Эрсдэл:***

Холбогдох хууль тогтоомж, заавар журмын хэрэгжилт хангагдахгүй байх

1.3. ***Өгсөн зөвлөмж:***

НББ-ын тухай хуулийг хэрэгжүүлж анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангуулж, эд хариуцагчийн ажлын хариуцлагыг дээшлүүлэх.

***2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:***

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн ..... дугаар тоот албан бичгээр хариуг ирүүлж хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Гурав. Баталгаажуулалт:

Тайлан бэлтгэсэн:
Гэрээт ажилтан Ш.УУГАНЖАРГАЛ

Анхан шатны чанарын хяналт хийсэн:
Аудитын менежер Б.ЭРДЭНЭ

Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн:
Дарга, тэргүүлэх аудитор Ц.НАРМАНДАХ

ОРА-2021/81/СТА-ТШЗ 18

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: | Аудитын нэр: | ***Орхон аймгийн Татварын хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | Аудитын код: |
| **2021** | | | ОРА-2021/81/СТА-ТЗШ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | **Орхон аймгийн Татварын хэлтэс** | | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Сар бүрийн цалингийн цэсийг тулган баталгаажуулах явцад 2020 оны 9, 11-р сааруудад шинээр томилогдсон Ц.Отгонцэрэнд 285.0, Д.Гэндэнпилд 275.3 нийт 560.3 мянган төгрөгийг илүү олгосон. | 560.3 | Төлбөрийн акт | Дарга, Нягтлан бодогч | Б.Цэвээнсүрэн О.Эрдэнэтунгалаг |
| 2 | Сар бүрийн цалингийн цэсийг тулган баталгаажуулах явцад 2020 оны 11,12-р сард жолооч Б.Өлзийбаярыг батлгадаагүй орон тоог хавсран гүйцэтгүүлэх шийдвэр гарган сарын үндсэн цалингийн 30 хувь буюу 311.7 мянган төгрөг илүү олгосон. | 311.7 | Төлбөрийн акт | Дарга, Нягтлан бодогч | Б.Цэвээнсүрэн О.Эрдэнэтунгалаг |
| 3 | НББ-ын тухай хуулийг хэрэгжүүлж анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангуулж эд хариуцагчийн хариуцлагыг дээшлүүлэх. | 576,3 | Зөвлөмж | Дарга, Нягтлан бодогч | Б.Цэвээнсүрэн О.Эрдэнэтунгалаг |
| **ДҮН** | | **1448.3** | | | |

<u>ХЯНАСАН:</u>
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ЭРДЭНЭ Огноо:

<u>БЭЛТГЭСЭН</u>:
ГЭРЭЭТ АЖИЛТАН Ш.УУГАНЖАРГАЛ Огноо:

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 сарын 25 өдөр  Дугаар 12/12 ОРА-2021/81/СТА-ТШЗ  Эрдэнэт хот

## ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн Татварын хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын даргын Б/21 дүгээр тушаалаар 8-р сарын 20-ны өдрөөс, Б/29 дүгээр тушаалаар 11-р сарын 9-ний өдрөөс томилогдсон алба хаагчдад тухайн саруудад бүтэн ажилласнаар тооцон 560.3 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-д " Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3."цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Орхон аймгийн Татварын хэлтсийн  илүү олгосон цалин 560.3 мянган төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 01-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Орхон аймгийн Татварын хэлтсийн дарга Б.Цэвээнсүрэн, нягтлан бодогч О.Эрдэнэтунгалаг нарт хариуцуулав.

[1] Монгол Улс, Орхон аймаг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-0757

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:.................................Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР.................................Б.ЭРДЭНЭ

АХЛАХ
АУДИТОР.................................Г.ОРГИЛМӨРӨН

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АКТ**

2021 оны 02 сарын 25 өдөр Дугаар 11/11 ОРА-2021/81/СТА-ТШ3 Эрдэнэт хот

### ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн Татварын хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Татварын Ерөнхий газрын даргын 2020 оны 05-р сарын 28-ны А/103 дугаар тушаалаар батлагдсан "харьяа нэгжийн орон тоог шинэчлэн батлах тухай" тушаалын хоёрдугаар хавсралтад тус хэлтэст цахилгаанчин-мужааны орон тоо батлагдаагүй байхад байгууллагын даргын 2020 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн А/61 дүгээр тушаалаар жолооч Б.Өлзийбаярт байгууллагын цахилгаанчин-мужааны ажлыг хавсран гүйцэтгүүлсэн гэж сар бүр үндсэн цалингийн 30 хувийн нэмэгдэл олгохоор шийдвэрлэн, 11,12 саруудад 311.7 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2."батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.3."батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.3.3."цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Орхон аймгийн Татварын хэлтсийн илүү олгосон нэмэгдлийн 311.7 мянган төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 01-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Орхон аймгийн Татварын хэлтсийн дарга Б.Цэвээнсүрэн, нягтлан бодогч О.Эрдэнэтунгалаг нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР.............................Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР.............................Б.ЭРДЭНЭ

АХЛАХ
АУДИТОР.............................Г.ОРГИЛМӨРӨН

[1] Монгол Улс, Орхон аймаг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-0757